

Б.Түвшинтөгс: Монгол шиг зах зээл нь тогтворгүй оронд ханшийг таана гэдэг бараг бүтэхгүй хэрэг

Ж.Тэгшжаргал

Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал Б.Түвшинтөгстэй ярилцлаа.

-2012 эхэлмэгцээ төгрөгийн ханшийг шалд нь буулгаж, ам.долларынхыг хүчтэй чангаруулж “гэнэтийн бэлэг” барилаа. Гэвч бид л үүнийг “гэнэтийн бэлэг” хэмээн хүлээн авч, мэдэн будилж байгаа болохоос биш гадаад худалдааны тэнцэл дохио өгсөөр л байсан. Өдгөө ам.долларын ханш эргээд сулрах найдлага байна уу?

-Ам.долларын ханш өссөнтэй холбогдуулж Засгийн газар, Монголбанк, бүр шатахуун импортлогчид хүртэл өөрсдийн тайлбарыг хийж байна. Бид харин үүнийг нь маш сайн нягтлах хэрэгтэй. Гадаад худалдааны тэнцлийн алдагдал 1.7 тэрбум ам.долларт хүрч, бүр урьд үзэгдээгүй их тоо харагдах болсон нь валютын гарах урсгал орж байгаагаасаа ихэссэн гэдгийг нотолж байна. Ийм үед ам.долларын ханш хүссэн хүсээгүй чангарна. Зарим хүн гадаадын шууд хөрөнгө оруулалт өссөн шүү дээ гэж байна. Гэтэл үүнээс ам.доллар хэлбэрээр орж ирж байгаа нь хэд вэ гэдгийг нягтлах хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулалт тоног төхөөрөмж хэлбэрээр ихээхэн орж ирж байгаа учраас валютын нийлүүлэлт талдаа хүчтэй нөлөөлж чадахгүй байх шиг байна.

-Ам.долларын ханш буурах үзэгдэл харагдаж байгаа ч яг өссөн хэмжээндээ хүрч буухгүй байна. Уг валютын өнөөгийн ханшийг та хэр бодитой гэж үзэж байна вэ?

-Бодитой биш ханш гэж байдаггүй. Ямар ханшийг бодитой гэж үзэж байгааг тань мэдэхгүй учраас тайлбар хэлж чадахгүй нь. Мэдээж валютын ханш савлах нь эдийн засагт сайн зүйл авчрахгүй. Гэвч энэ бол зах зээл дээр тогтоогдож байгаа ханш гэдгийг бид хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй. Харин бид буруутанг хайхаасаа илүү энэ савлагааг аль болох багасгах талд гарц хайх нь дээр байх.

-Оюутолгой олборлолтоо эхэлж, Тавантолгойн нүүрсний экспортын хэмжээ нэмэгдээд ирэхээр урт хугацаандаа ам.долларын ханш буурна гэсэн хүлээлт бий боллоо. Ингэж найдаж болох уу?

-Өнгөрсөн оны нэгдүгээр сард төгрөгийн ханш чангарна гэсэн хүлээлт түгээмэл байсан. Ам.долларын нэрлэсэн ханш бараг 1000 төгрөгтэй дүйнэ л гэж хүлээж байсан. Гэтэл өдгөө нөхцөл байдал яаж эргэв. Мөнгөний нэрлэсэн ханшийг таамаглах оновчтой загвар онолын хувьд ч байдаггүй. Ялангуяа Монгол шиг зах зээл нь тогтворгүй оронд ханшийг таана гэдэг бараг бүтэхгүй хэрэг л дээ. Сая ам.долларын ханш 1480 төгрөг хүрэхэд бид нэн тэргүүнд хэн буруутай вэ гэдгийг хайж эхэлсэн. Гэтэл үүний суурь нөхцөл болох валютын орж, гарч байгаа урсгалд бид хяналт тавьж чаддаг билүү. Харамсалтай нь үгүй.

-Гэхдээ хариу үйлдэл хийсэн юм биш үү. Монголбанк оны эхэнд хэдэн өдөр дараалж интервенц хийлээ. МҮЭ-ийн холбоо бүр 200 сая ам.долларын интервенц хийхийг шаардаж байгаа тухай та сонссон байх?

-УИХ-аар баталсан хуулиар бол Монголбанк валютын огцом хэлбэлзлийг алга болгох, сааруулах үүрэг хүлээсэн. Гэхдээ тэд валютын ханш хэдий хугацааны турш, хэдэн төгрөгтэй тэнцэхийг огцом хэлбэлзэл гэж үзээд, интервенц хийдэг вэ гэдгийг тодруулах хэрэгтэй байна. Тоглоомынхоо дүрмийг эхлээд тодорхой болгох хэрэгтэй. Миний ойлгож буйгаар Монголбанк саяхан валютын ханшийн огцом хэлбэлзэл үүслээ гэж үзээд интервенц хийсэн байх. Тэгвэл интервенц хийсэн хэмжээ нь яагаад харьцангуй бага байна вэ. Жишээ нь, хамгийн сүүлийн интервенцээр хоёр сая ам.доллар л худалдсан байна. Бидний бодож байсан шиг 200, 300 сая ам долларын эрэлт байхгүй байж. Банкууд ч ам.долларын төлөө уралцсангүй, Монголбанк он гараад хамгийн ихдээ л 66 сая ам.долларын интервенц хийсэн байсан. Тэгэхээр зах зээлд ам.долларын тийм ч айхавтар огцом хомсдол байхгүй байгаа учраас өнөөдрийн ханшийг харьцангуй тэнцвэртэй, эсвэл тэнцвэр лүүгээ аажим явж байна гэсэн дохиог өгч байна.

-Тэгвэл ам.доллар тэгтлээ ховордоогүй үед цөөнгүй удаа интервенц хийсэн нь зах зээлд ямар сөрөг үр дагавар үүсгэх вэ?

-Ханшийн бодлого, мөнгөний бодлого хоёр бол нэг зоосны хоёр тал. Интервенц хийнэ гэдэг нь жишээ нь, ам.доллараа зараад, хариуд нь төгрөгөө татах үйл явц. Тэгэхээр энэ нь төгрөгийн нийлүүлэлтэд хүссэн, хүсээгүй нөлөөлж таарна. Гэтэл Монголбанк өөрөө төгрөгийн нийлүүлэлтийг тодорхойлдог байгууллага шүү дээ. Хаа хамаагүй интервенц хийгээд байх нь эргээд төгрөгийн нийлүүлэлтийн бодлоготой тэрсэлдэж эхэлнэ. МҮЭ-ийн холбоо 200 сая ам.долларын интервенц хий гэж шаардаж буйг би хамгийн муу бодлогын сонголт гэж хэлнэ. Банкууд авъя гэхгүй, валютын ихээхэн хомсдол нүүрлээгүй байхад дээрх хэмжээний ам.долларыг зах зээлд хүчээр шахвал мөнөөх 200 сая ам.доллартай тэнцэхүйц төгрөгийг Монголбанк эргээд татах болно. Энэ нь харин компаниуд руу очиж байгаа зээлийн эх үүсвэрийг бууруулна. Бид үүнийг хүсэж байна уу? Үгүй. Энэ мэтийн популист маягийн зүйл сүүлийн үед цөөнгүй гарах боллоо. Би хувьдаа иймэрхүү өдөөн хатгалгад автахгүй байгаа Монголбанкны чиг баримжааг зөв гэж бодож байна. Төвбанк бие даасан байдлаар төгрөгийн нийлүүлэлт, инфляцтай уялдсан бодлогоо явуулах хэрэгтэй.

-Гэвч байдал бидний санаснаас тэс өөрөөр эргэж байна. Дээрх асуудлаас болоод Монголбанкны ерөнхийлөгчийг ажлаас нь халах тухай ч ярьж эхэлсэн шүү дээ.

-Хэрэв би буруу бодоогүй бол өнгөрсөн оны сүүлчээр УИХ-ын гишүүд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг баталсан биш билүү. Гэтэл нэг сар ч өнгөрөөгүй байхад өөрсдийн баталсан хуультайгаа тэрсэлдээд эхэлсэн нь ойлгомжгүй санагдаж байна. Манайд үүссэн нэг буруу тогтолцоо нь УИХ шинээр томилогдох тоолонд Төвбанкныхаа ерөнхийлөгчийг сольдог. Хуулиараа бол Төвбанкны ерөнхийлөгчийн алба зургаан жилийн хугацаатай бөгөөд энэ нь нэг Засгийн газраас нөгөөд шилжихэд бодлогын залгамж холбоог хадгалах чухал үүрэгтэйбайдаг. Жишээ нь, АНУ-ын Бүгд найрамдах намын угшилтай ерөнхийлөгч Ж.Бушын томилсон Бен Бернанке гэх хүнийг Ардчилсан намаас сонгогдсон ерөнхийлөгч Б.Обама Төвбанкныхаа тэргүүнээр өдгөө ч ажилуулж байна. Төвбанкны ерөнхийлөгч бол бодлогын залгамжийг хадгалдаг

маш чухал албан тушаал учраас сонгох, халах зэрэг асуудалд өндөр хариуцлагатай хандах хэрэгтэй.

-Гадаад худалдааны алдагдал урьд үзэгдээгүйгээр өссөн тухай бид өмнө нь ярьсан. Тэрхүү үлэмж алдагдал энэ онд ч буухиалж мэдэхээр байна. Энэ нь валютын ханшаас гадна эдийн засгийн бусад салбарт хэрхэн сөргөөр нөлөөлөх вэ?

-Монгол бол валютын ханшийн хөвөгч тогтолцоотой орон. Бидэндвалютын хангалттай нөөц байхгүй учраас(2.5 тэрбум ам.доллар)тогтмол ханштай орон байж дөнгөхгүй. Хөвөгч тогтолцооны нэг давуу тал нь гадаад худалдааны алдагдал огцом өсөөд эхэлбэл ханшийн өсөлтөөр шокийг шингээж авах боломжтой. Бодит эдийн засагт нөлөөлөх нөлөөллийг нь багасаж, сааруулж байна гэсэн үг. Мэдээж үнийн түвшинд хүчтэй нөлөөлөх ч, ханшийн тогтмол тогтолцоотой харьцуулбал үйлдвэрлэлийн түвшин харьцангуй багаар өөрчлөгддөг. Дэлхийн банк, ОУВС “Хөвөгч ханшийн тогтолцооны давуу талыг 100 хувь эдлэхийн тулд ханшийн бодлогоо хаях хэрэгтэй” гэж зөвлөдөг. Валютын ханшид ямар нэг зохицуулалт хийлгүй, зах зээлийнх нь өөрийн зарчмаар явуулж, харин мөнгөний бодлогоо инфляц дээрээ төвлөрүүл гэдэг. Өдгөө Монголбанк дутуу, хагас интервенцээр оролцож байгаа нь хүмүүст хүлээлт үүсгэж байна. Практик дээр авч үзвэл хөгжиж байгаа орнууд ханшаа 100 хувь хаяж ерөөсөө ч чаддагүй. Ханшийн огцом хэлбэлзэл нь үнэд, улмаар амьжиргааны түвшинд хүрч нөлөөлдөг учраас тэр. Тийм учраас ханшны зохицуулалтыг ямар нөхцөлд хийж байгаа талаар илүү тодорхой болгох нь зүйтэй болов уу.

-Валютын ханштай холбоотой дээрх “муу мэдээ”-нээс гадна, манай улсын эдийн засгийн өсөлтийн талаар өөдрөг төсөөллүүд гарах болсоор удлаа. Иргэд чухам алинд нь итгэхээ мэдэхээ больж байх шиг.

-Манай улсын эдийн засаг маш хурдацтайгаар өсөж байгаа нь үнэн. Харин энэ өсөлт нь дундаж иргэний амьжиргаанд хүрч нөлөөлж байна уу. Ядуурлын түвшин 39 хувьтай байгаагаас харахад уучлаарай, үгүй юм байна. Үүнээс гадна бас нэг эрсдэл байгаа нь өдгөө алт, зэсийн үнэ хэрэв буурвал манай улсын эдийн засаг

2008, 2009 оны хямралын жилийнх шиг шалдаа бууж мэднэ. 2008 оны эхний гурван улиралд алт, зэсийн үнэ харьцангуй өндөр, Засгийн газрын зарлага, мөнгөний нийлүүлэлт ч айхавтар өссөн. Гэтэл хямрал бий болмогц Засгийн газрын орлого нь байхгүй боллоо, мөнгөний бодлого өндөр инфляцтай нүүр туллаа, эргээд бодлогоо чангатгах хэрэгтэй болсон. Мөнгөний бодлогоо чангатгахын тулд валютаа зарж, бүр 500-хан сая ам.доллартай үлдэж, улмаар ОУВС-гаас 229 сая ам.долларын зээл авч байлаа. Одоо иймэрхүү үйл явдал давтагдахгүй гэх баталгаа алга. Өдгөө алт зэсийн үнэ өндөр байна, үүнийгээ дагаад Засгийн газрын зарлага их, төсөв хэт тэлсэн байна. Үүн дээр шок ирвэл дахиад л сөхрөхөд бэлэн л байна.

-Энэ бол “хэрвээ” гэсэн таамаглал. Хэрвээ ийм явдал тохиолдож мэдэхээр байгаа бол бид 2008 оных шиг хямрахгүйн тулд юу хийх хэрэгтэй вэ?

-2008 оны хямралаас хойших сүүлийн гурван жилд бид хангалттай дархлаажиж, алдаанаасаа суралцаж чадсан билүү?

-Харамсалтай нь үгүй. Харин ч их ачаа нуруундуу үүрчихсэн байна.

-Ирэх онд Төсвийн тогтвортой байдлын тухай хууль хэрэгжиж эхэлбэл энэ нь хамгаалалтын нэг тогтолцоо болох боломжтой. Харамсалтай нь тэр бол 2013 он.